# ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Тендерийн код: МРЦМ/20240102251**
**Тендерийн нэр: Хамгаалах хэрэгслүүд**
**Багцийн тоо: 2 багцтай**

**Барааны тавигдах ерөнхий мэдээлэл болон тавигдах шаардлага:**

**Зориулалт:** Тухайн тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх хамгаалалтын хэрэгслүүдийг Захиалагчийн “Бор-Өндөр” УБҮ болон “Шижир алт” алтны үйлдвэрийн ил болон далд уурхайн олборлолт, баяжуулалт болон бусад холбогдох үйлдвэрлэлд ажиллагсдын эрүүл ахуйн хамгаалалтын зориулалтаар ашиглана.

**Нийлүүлэгдэх тоо, хэмжээ**:

| № | Нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---|---|---|---|
| | **Багц №1. Хамгаалах хэрэгслүүд** | | |
| 1 | Амны хаалтны шүүлтүүр /гадна нөхцөлд ашиглах фильтертэй амны хаалтны / | хос | 8 |
| 2 | Чихний бөглөөс | хос | 13000 |
| 3 | Нүдний шил /4 төрөл/ | ширхэг | 2000 |
| 4 | Нүүрний хамгаалалт баг | ширхэг | 50 |
| 5 | Гагнуурын маск /энгийн/ | ширхэг | 14 |
| 6 | Гагнуурын маск /хамелеон/ | ширхэг | 48 |
| 7 | Гагнуурын маскны шил /хамелеон/ | ширхэг | 252 |
| 8 | Гагнуурын маскны шил /энгийн/ | ширхэг | 864 |
| 9 | Уурхайн аврах баг | ширхэг | 103 |
| 10 | Малгайн гэрэл | ширхэг | 60 |
| 11 | Дуулга /каск/ /ил уурхайд ашиглах / | ширхэг | 110 |
| 12 | Дуулга /каск/ далд уурхайд ашиглах | ширхэг | 100 |
| 13 | Засварчны өвдгөвч | Хос | 100 |
| 14 | Түлшний сав цэвэрлэгээний баг /хорт хий, угаарын дамартай хоолойтой/ | ширхэг | 3 |
| | | | |
| | **Багц №2 Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн иж бүрдэл** | | |
| | Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нэгж багцад хамаарах зүйлс:Үүнд: | Иж бүрэн | 100 |
| 15 | Бээлий болон түлхүүрний хавчаар | ширхэг | 100 |
| 16 | Хүчдэл мэдрэгч | ширхэг | 100 |
| 17 | Саравчтай хамгаалалтын малгай | ширхэг | 100 |
| 18 | Бээлий | хос | 100 |
| 19 | Камер /хоёр талын бичлэг хийх чадвартай | ширхэг | 100 |

**Багц №1. ХАМГААЛАХ ХЭРЭГСЛҮҮД**

1. **АМНЫ ХААЛТНЫ ШҮҮЛТҮҮР/гадна нөхцөлд ашиглах фильтертэй амны хаалтны /**

**Тавигдах шаардлага:**

| № | Үзүүлэлт | Жишиг зураг |
|---|---|---|
| 1 | Нийлүүлэх шүүлтүүр нь Honeywell 5500 загварын хагас нүүрний баганд ашиглахад таарахаар байна |  |
| 2 | "75SCL Defender Multi-continminants cartridge" загвар/эсхүл түүнтэй дүйцэх шүүгч бортого байна. | |
| 3 | Хийц: Бортого, шүүлтүүр, шүүлтүүр тогтоогчоос бүтсэн байна. | |
| 4 | Хамгаалалт: Төрөл бүрийн хий/органик уур (Органик уур, аммони, метиламин, формальдегид ба хүчлийн хий (хлор, хлорт устөрөгч, хүхрийнн давхар исэл, устөрөгчийн сульфид, фторт устөрөгч ба хлорын диоксид г.м.) | |

**2. ЧИХНИЙ БӨГЛӨӨС**

**Тавигдах шаардлага:**

| № | Үзүүлэлт | Жишиг зураг |
|---|---|---|
| 1 | Сонсгол хамгаалах хэрэгсэл нь "Хөдөлмөр хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага MNS 4931:2000" стандарт болон EN 352-2:2002, EN13819-1:2002, EN13819 -2:2002 стандарттай дүйцэхүйц стандартын шаардлагыг хангасан байна. |  |
| 2 | Чихний бөглөө нь биед харшил болон чихний сүвэнд цочроо өгөхгүй, шуугианы давтамжийг 31-37 дБ хүртэл бууруулах чадвартай байна. | |
| 3 | Чихний бөглөө нь биеийн дулааныг мэдэрч чихний сүвэнд шуугиан орох зайгүйгээр суух, үеийн нугаламтай, агшиж тэлэх чадвартай хоорондоо утсаар холбогдсон байна. | |

## 3. НҮДНИЙ ШИЛ

Хөдөлмөр хамгаалалын нүдний шил нь Монгол улсын MNS 5389:2004, Олон улсын EN 166:2002 стандартын шаардлагыг бүрэн хангасан байна. Европын холбооны EN 166 стандартын шаардлагад нийцсэн болох тэмдэглэгээтэй, чанарын стандартын тэмдэгийг шилний шошго зааварт бичсэн байна.

**Материал:** Поликарбонат ашиглан PVC-Полиамид, полиэтилен материалаар хийгдсэн байна.

Бүтэц: Дан шил /линз/, нүдний шилний хүрээ, бэхлэгч оосор /резинэн, хатуу тогтоогч/, зүүлтийн уян гар, хамрын жийргэвч, нүдний шил тогтоогч уяа зэргээс бүтнэ.

**Ерөнхий шаардлага:**

1. Шилний үзүүлэлт нь салхины хүч 15-19 м/с үед хамгаалах чадвартай, нарнаас хамгаалах гэрлийн бууралттай /0-11 DIN бууруулах/ байна.
2. Ажлын бүтэн ээлжийн турш нүдний шилийг зүүн ажиллахад нүд ядрахгүй байх ёстой.
3. Шил нь өөгүй, аливаа дүрсийг бодитоор харуулах, ямар нэгэн гэрлийн урвалгүй (нөлөөгүй), хараанд нөлөөлөхгүй хэвийн үзүүлэлттэй байна.
4. Нүдний шил нь хэрэглэхэд хялбар, нүдэнд орж болзошгүй тоос, шороо, механик биет болон хурц гэрлээс хамгаалах ба шилний зузаан нь 2мм-с доошгүй байна.
5. Мөн шил нь аливаа механик үйлчлэлийн хүчээр хагарч бутардаггүй байх шаардлагатай.
6. Шанааны хэмжээ болон хамрын угт тохирсон, чамархай болон хамрын хянганы ясанд даралт учруулахгүй байх шаардлагатай.
7. Цохилтоос хамгаалах, зурагдахгүй, цантахгүй, сөрөг нөлөөгүй байх.
8. Мултарч унахаас сэргийлж, нүдний шил тогтоогч уяатай байна.
9. Хамрын зөөлөвчтэй байна.

**Сав баглаа боодол:** Нүдний шилийг хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аливаа гэмтэл бэртэлээс сэргийлсэн чанарын шаардлага хангахуйц сав баглаа боодолтой байна.

**Нийлүүлэгдэх хэлбэр, загвар болон тоо ширхэг**

| № | Барааны нэр | Тоо ширхэг |
|---|---|---|
| 1 | Тунгалаг шил | 1000 |
| 2 | Шар өнгөтэй | 800 |
| 3 | Тунгалаг нарийн тоос шороны хамгаалалттай шил | 100 |
| 4 | Хар өнгөтэй | 100 |
| | **НИЙТ:** | **2000** |

**3.1. Нүдний шил /Өнгөгүй тунгалаг/**

| | | |
|---|---|---|
| 1 | Материал | Поликарбонат ашиглан PVC-Полиамид. Portwest брендийн нүдний шил эсхүл түүнтэй дүйцэхүйц байна. |
| 2 | Тоо ширхэг | 1000 /нэг мянга/ |
| 3 | Зориулалт | Тасалгаанд ажиллах болон үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд ажиллах үед хэрэглэнэ |
| 4 | Үзүүлэлт | • Тунгалаг өнгөтэй<br>• Поликарбонат 2.1мм-с ихгүй зузаан шилтэй<br>• EN 166 стандартыг хангасан<br>• Жин- 28гр-с багагүй<br>• Зурагдалтын эсрэг сайн хамгаалалттай<br>• Цантдаггүй<br>• Гар нь зөөлөн, холгодоггүй байх<br>• Нүдний шил тогтоогч уяатай байна. |
| 5 | Жишиг зураг |    |

**3.2. Нүдний шил /Тунгалаг өнгөтэй, нарийн тоос, тоосонцорын хамгаалалттай/**

| | | |
|---|---|---|
| 1 | Материал | Поликарбонат ашиглан PVC-Полиамид. Portwest брендийн нүдний шил эсхүл түүнтэй дүйцэхүйц байна. |
| 2 | Тоо ширхэг | 100 /нэг зуу/ |
| 3 | Зориулалт | Нарийн тоос, тоосонцортой орчин, Хий болон химийн шингэн цацарсан тусал нүдрүү орохоос хамгаалах зориулалттай |

| | | |
|---|---|---|
| 4 | Үзүүлэлт | • Нүдний шил нь тунгалаг<br>• Поликарбонат 2.1мм-с зузаангүй шилтэй<br>• Шилний марк- Portwest PW25  эсхүл түүнтэй дүйцэхүйц<br>• EN 166 стандартын шаардлагыг хангасан<br>• Нарийн ширхэгт тоос, тоосонцорын хамгаалалттай<br>• Тоосны маск, нүүрний хагас маскан дээр зүүх боломжтой<br>• Хий, химийн шингэний цацарсан тусал нүд рүү орохоос хамгаалсан<br>• Зурагдалтын эсрэг сайн хамгаалалттай<br>• Цантдаггүй<br>• Хөнгөн жинтэй, |
| 5 | Жишиг зураг |  |

| **3.3. Нүдний шил /Шар өнгөтэй /** | | |
|---|---|---|
| 1 | Материал | Поликарбонат ашиглан PVC-Полиамид.  Portwest брендийн нүдний шил эсхүл түүнтэй дүйцэхүйц байна. |
| 2 | Тоо ширхэг | 800 /найман зуу/ |
| 3 | Зориулалт | Хэт ягаан туяа болон хүний нүдэнд сөрөг нөлөөтэй нөхцөлд ажиллах үед хэрэглэнэ |
| 4 | Үзүүлэлт | • Нүдний шил шар өнгөтэй<br>• Поликарбонат 2.1мм-с зузаангүй шилтэй<br>• Европын холбооны EN 166 стандартыг хангасан<br>• Зурагдалтын эсрэг сайн хамгаалалттай<br>• Цантдаггүй<br>• Тогтоогч гар зөөлөн, холгодоггүй байх<br>• Нүдний шил тогтоогч уяатай байна. |
| 5 | Жишиг зураг |  |

| 3.4. Нүдний шил /Хар өнгөтэй / | | |
|---|---|---|
| 1 | Материал | Поликарбонат ашиглан PVC-Полиамид. Portwest брендийн нүдний шил эсхүл түүнтэй дүйцэхүйц байна. |
| 2 | Тоо ширхэг | 100 /нэг зуу |
| 3 | Зориулалт | Гадаад орчинд буюу нарны гэрэлтэйд ажиллах үед хэрэглэнэ /шил нь нарнаас хамгаалах гэрлийн бууралттай байна/ |
| 4 | Үзүүлэлт | • Нүдний шил нь хар өнгөтэй<br>• Поликарбонат 2.1мм-с зузаангүй шилтэй<br>• EN 166 стандартыг хангасан<br>• Зурагдалтын эсрэг сайн хамгаалалттай<br>• Цантдаггүй<br>• Гар нь зөөлөн, холгодоггүй байх<br>• Нүдний шил тогтоогч уятай байна. |
| 5 | Жишиг зураг |   |

## 4. НҮҮРНИЙ ХАМГААЛАЛТЫН БАГ /маск/

**Зориулалт:** Нүүрийг хурдтай хатуу биет, шингэн цацрахаас, хэт ягаан туяанаас хамгаалах зориулалттай. Цохилтод тэсвэртэй поликарбонит материалаар хийгдсэн, хортой туяа болон цахилгаан нумаас хамгаалах, цохилтыг тэсвэрлэх чадвартай болон хамгаалалтыг дээш, доош сөхөж, буулгах боломжтой байх.

| Үзүүлэлт | Жишиг зураг |
|---|---|
| **1. Хамгаалалтын материал:**<br>Тогтоогч: Полиэтилен терафаталат /PBT/<br>Хаалт: поликарбонат<br>Бүтэц:V-Gard Нүүрний хаалт,<br>V-Gard HDPE тогтоогч хүрээ |  |
| 2. Үзүүлэлт:<br>1 Олон улсын чанарын стандарт EN 166 EN 1731 стандартын шаардлагыг хангасан байх.<br>2 Харах талбайд саад болохгүй өргөн<br>3 Хөдөлгөөнд саад болохгүй таруулж болдог<br>4. Хэрэглэхэд хялбар байх<br>5. Хаалтыг амархан салгаж болдог<br>6. Чихэвч зүүхэд саад болохгүй<br>7. Хөнгөн овор бага<br>8. Өнгө хар | |

### 5. ГАГНУУРЫН МАСК /энгийн хамелеон/

Дараах ерөнхий шаардлагад нийцсэн байна:

1. Гагнуурчны хамгаалах багны их бие нь хөнгөн, бат бөх чанартай, галд тэсвэртэй материалтай байх.
2. Ямар ч байрлалд гагнуур хийхэд тохиромжтой, толгойн хэмжээнд тааруулж тохируулах зориулалттай, урагш болон хойшоо тохируулгатай, нүүрэн хэсэг нь сөхөгддөг байх.
3. Туяанаас хамгаалах шил болон харах шилийг солих боломжтой энгийн хамгаалах баг байх

Техникийн үзүүлэлт:

| Үзүүлэлт | Утга |
|---|---|
| Туяанаас хамгаалах шүүлтүүртэй шилний хэмжээ, мм | 90x110 |
| Харах шилний хэмжээ, мм | 90x110 |
| Багны хэмжээ, мм | 210x285x195 |
| Жин, гр | 350-400 |
| Зориулалт | Цахилгаан нуман гагнуур, хагас автомат гагнуур, аргон гагнуурт ашиглах зориулалт бүхий хамгаалалтын баг байх |
| Жишиг зураг | |
|  |  |

### 5. ГАГНУУРЫН ХАМГААЛАЛТЫН БАГ /маск хамелеон/

**Зориулалт:** Гагнуурчны нүүрийг гагнуурын нумын гэрлийн цацрал болон хайлмаг төмөрлөгийн үсрэлтээс хамгаалах үүрэгтэй. Халхавч баг ба нүүрэвч нь гагнуурчны нүд, нүүрний арьсыг хайлмаг шингэн металлын үсрэлт, нумын туяаны хорт үйлчлэлээс хамгаална.

| Үзүүлэлт | Утга |
|---|---|
| Тодорхойлолт | 1. Автомат электрон гагнуурын баг (дуулга)<br>2. MMA, MIG, TIG болон GRIND процессуудад тохиромжтой байх. |
| Ерөнхий үзүүлэлт | Нүүрний хамгаалалт линз: – electonico<br>Харанхуй төлөвийн хамгаалалт: – байна<br>Харагдуулах талбайн хэмжээ (L X A): – 98 x 55 мм<br>Нүүрний хамгаалалтын линзний гэрлийн зэрэг:– 13<br>Өнгө: Хар, бусад өнгө алагласан байж болно<br>Нум мэдрэгчийн тоо:– 2-оос доошгүй |

| | |
|---|---|
| | Батарей: – Нарны,гэрлээр цэнэглэдэг<br>Онцгой шинж:  - хурц болон хэт ягаан туяаны хамгаалалттай |
| Бусад үзүүлэлт | Ерөнхий хэмжээс:<br>• Урд тал: 240.0 мм орчим<br>• Гүн: 240.0 мм орчим<br>• Өндөр: 320.0 мм орчим<br>• Жин: 870.0 гр орчим орчим<br>Нарны цэнэглэгч тольны хэмжээ: - 124.5x 100.5 x 18 мм орчим<br>Сүүдрийн гэрлийн төлөв: - DIN 4<br>Харанхуй төлөвийн сүүдэр: - DIN 5-9 / 9-13<br>Харанхуй төлөвийн тохиргоо: - Гадаад хяналт, тасралтгүй<br>Солих хугацаа: - 1/10000 секунд<br>Мэдрэмжийн хяналт: - Гадны, тасралтгүй хяналт<br>Сэргээх хугацаа: - 0.1 / 0.4 / 0.8 секунд<br>Эрчим хүчний эх үүсвэр: - Литий батерей/Нарны хавтан<br>Литиум батерейны нэрлэсэн хүчин чадал: - 1200mAH<br>Зайг солих боломжтой эсэх: - Тийм<br>Ашиглалтын температур: -20 ° -аас 65 ° С хүртэл<br>Багны материал: - PP<br>Хэт ягаан туяаны хамгаалалт: - DIN 16<br>Өөрийгөө шалгах үзүүлэлт: - байна<br>Бага хүчдэлийн анхааруулга: - байна<br>Жинхэнэ өнгөт линз: - Үгүй |
| Жишиг зураг |  |

## 7. ГАГНУУРЫН МАСКНЫ ШИЛ /хамелеон/

### 1. Зориулалт:

1.1. Автоматаар сүүдэрлэх – энэ нь гагнуурын төлөвт автоматаар сүүдэрлэж, хортой туяа, гэрлийг шүүж чаддаг.
1.2. 8-12 хүртэлх гүн харанхуйлах тохиргоотой
1.3. Харанхуйлах хурдны хэмжээг тохируулдаг
1.4. Харнхуйгаас гэрэлд нээгдэх хугацааг тохируулдаг

| Үзүүлэлт | Утга |
| --- | --- |
| Тодорхойлолт | 1. Төрөл – SHADE: 3/11<br>2.Автомат харанхуйлах Хурц гэрэлд автоматоор харанхуйлагч шил<br>3. AS/NZS 1338.1 стандартаар баталгаажсан<br>4. High Clear View - Өндөр тунгалаг харах шүүлтүүр LCD болон олон давхаргат оптик интерференцийн шүүлтүүрийг өндөр стандартаар ашиглана. |
| Ерөнхий үзүүлэлт | Нүүрний хамгаалалт линз: – electonico<br>Харанхуй төлөвийн хамгаалалт: – байна<br>Харагдуулах талбайн хэмжээ (L X A): – 98 x 55 мм<br>Нүүрний хамгаалалтын линзний гэрлийн зэрэг:– 13<br>Өнгө: Хар, бусад өнгө алагласан байж болно<br>Нум мэдрэгчийн тоо:– 2-оос доошүй<br>Батарей: – Нарны,гэрлээр цэнэглэдэг<br>Онцгой шинж: - хурц болон хэт ягаан туяаны хамгаалалттай |
| Техникийн үзүүлэлт | - Материал: PP полипроплен<br>- Урт: Ойролцоогоор. 108 мм / 4.25 инч<br>- Өргөн: Ойролцоогоор. 51 мм / 2.01 инч<br>- Гэрлийн төлөв: DIN3.5<br>- Харанхуй төлөв: DIN11<br>- Харах талбай: Ойролцоогоор. 91.5 x 34 мм / 3.6 x 1.34 инч<br>- Эрчим хүч: Нарны / Литиум батерей, батерейг солих шаардлагагүй<br>- Лити батерейны хүчин чадал: 60mAH<br>- Урвалын хугацаа: 4/10,000 секунд<br>- Харанхуйгаас цайвар хүртэл саатал: 0.2 секунд<br>- Ашиглалтын температур: -10℃～65℃ |
| Савлагаа | 10 ширхэг гагнуурын маскны шил 1 хайрцагт савалгаатай байна. / нийлүүлэгдэх гагнуурын хамелон багт тохирсон байна. / |
| Жишиг зураг |     |

## 8. ГАГНУУРЫН МАСКНЫ ШИЛ /энгийн

Шилний техникийн үзүүлэлт:

| № | Үзүүлэлт | Утга |
|---|---|---|
| 1 | Туяанаас хамгаалах шүүлтүүртэй шилний хэмжээ, мм | 90х110 |
| 2 | Зориулалт | Цахилгаан нуман гагнуур, хагас автомат гагнуур, аргон гагнуурт ашиглах зориулалттай |
| 3 | Нийлүүлэгдэх тоо хэмжээ, савлагаа | 864 ширхэг<br>Савлагаа: 10 ширхэг гагнуурын маскны шил 1 хайрцагт савалгаатай байна.<br>/ нийлүүлэгдэх гагнуурын хамелеон багт, тохирсон байна. / |
| 4 | Жишиг зураг |  |

## 9. Уурхайн аврах баг /далд уурхайн/

Далд уурхайд ашиглагдах уурхайн аврах баг нь СПП-4, ZYX 45 загварууд, эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.

Үндсэн шаардлага: Агаарын температур +2°С - с 50°С хүртэл өөрчлөгдөхөд агаар дахь хүчилтөрөгчийн агууламж 17%-с багагүй, нүүрстөрөгчийн дутуу ислийн концентраци эзлэхүүний 1% -с ихгүй үед багны ажиллах хугацаа 45-60 минутаас багагүй байна.

Техникийн үзүүлэлт:

| № | Нэршил | | Нэмжих нэгж | Тоон үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Хамгаалах багны жин | | кг | 1.5-с ихгүй |
| 2 | Овор хэмжээ | | мм | 135х85х130 |
| 3 | Агаар урсгал 30 л/мин байх үед багны бэлтгэл ажлын үеийн агаарын урсгалын тогтмол эсэргүүцэл | агаар сорогдоход | Па (мм.вод.ст) | 246 (25)- ихгүй |
| | | агаар гаргахад | | 128 (13)- ихгүй |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>Па (мм.вод.ст)</td><td></td></tr>
<tr><td rowspan="2">4</td><td rowspan="2">Агаар урсгал 30 л/мин байх үед багны ашиглалтын үеийн агаарын урсгалын тогтмол эсэргүүцэл</td><td>агаар сорогдоход</td><td>Па (мм.вод.ст)</td><td>294 (30)- ихгүй</td></tr>
<tr><td>агаар гаргахад</td><td>Па (мм.вод.ст)</td><td>128 (13)- ихгүй</td></tr>
<tr><td>5</td><td>Нийлүүлэх тоо</td><td></td><td>ширхэг</td><td>103</td></tr>
<tr><td></td><td>Жишиг зураг</td><td colspan="3">
</td></tr>
</table>

## 10. Дуулга/ Малгайн гэрэл

Далд уурхайн хамгаалалтын дуулганд зүүж ашиглах малгайн гэрэл нь СГСВ-6 «ЭКОТОН-6» эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.

Ерөнхий үзүүлэлт

| № | Нэршил | Нэмжих нэгж | Тоон үзүүлэлт |
|---|---|---|---|
| 1 | Цэнэг хураагуурын хэвийн хүчдэл | В | 3,7 |
| 2 | Хэрэглээний хүчин чадал | Вт | 1,2-с (ихгүй) |
| 3 | Гэрэлтүүлэх талбай | м2 | 1500 |
| 4 | Тусгалын өнцөг | градус | 8 (20.5) |
| 5 | Гэрлийн шилний ашиглалтын хугацаа | цаг | 50 000 |
| 6 | Тасралтгүй ажиллах хугацаа | цаг | 15-с (багагүй) |
| 7 | Тасралтгүй цэнэглэх хугацаа | цаг | 12-с (ихгүй) |
| 8 | Цэнэг хураагуурын цэнэглэлтийн дундаж давтамж | цикл | 1000 |
| 9 | Толгойн гэрлийн жин | гр | 170-с (ихгүй) |
| 10 | Цэнэг хураагуурын жин | гр | 400-с (ихгүй) |
| 11 | Толгойн гэрлийн ашиглалтын хугацаа | жил | 2 жилээс багагүй |
| 12 | Дагалдах хэрэгсэл | ш | Нөөц гэрлийн шил |
| 13 | | ш | Цэнэглэгч |
| 14 | | ш | Ашиглалтын паспорт |
| 15 | Гэрэл тус бүр хайрцаг баглаа савтай байх | | |

| | | | |
|---|---|---|---|
| 16 | Баталгаат хугацаа | сар | 6 |
| 17 | Нийлүүлэх тоо хэмжээ | ширхэг | 60 |
| | Жишиг зураг |    | |

**ТОЛГОЙ ХАМГААЛАХ ДУУЛГА:**

**1.Ерөнхий шаардлага**

1.1 Дуулга нь толгой хамгаалах хэрэгслийн ерөнхий шаардлага MNS 5621:2006 болон EN 397 олон улсын стандартын шаардлагыг хангасан байна.

**2.Тусгай шаардлага**

2.1. Толгой хамгаалах дуулга нь толгой дээр гадны биет унахад толгойг хамгаалахаас гадна, хөлсийг зайлуулах агааржуулагчтай байна.

2.2. Дуулганы баруун талд “Бор-Өндөр” УБҮ-ийн лого, Дуулганы зүүн талд ISO 45001 стандартын логог маш сайн чанарын стикерээр наах эсхүл будаж лазераар шивсэн байна.

Логоны хэмжээ диаметр 50мм

| № | **Нийлүүлэгдэх тоо ширхэг** | |
|---|---|---|
| 1 | Дуулга /каск/ ил уурхайд ашиглагдах | **110** |
| 1.1 | Өнгө /цагаан/ инженер техникийн ажилтан | 30 |
| 1.2 | Өнгө /шар/ ажилтан | 80 |
| 2 | Дуулга /каск/ ил уурхайд ашиглагдах: Үүнээс | **100** |
| 2.1 | Өнгө /цагаан/ инженер техникийн ажилтан | 30 |
| 2.2 | Өнгө /шар/ ажилтан | 70 |

**11. Толгой хамгаалах хэрэгсэл-Дуулга /ил уурхайн дуулга/**

| **Үзүүлэлт** | **Шалгуур үзүүлэлтийн утга** |
|---|---|
| **Техникийн үзүүлэлт** | 1. Дуулгын ММ-механик үйлчлэл 400-1000 В цахилгаан хүчдэлээс хамгаалах,<br>2. $-50^{0}$С-ээ +150 температурын нөлөөнөөс хамгаалах,<br>3. толгойд ирэх 50 Дж цохилтын энерги толгойд хүрэхгүй байх,<br>4. 5кН-с их хүчийг толгой руу дамжуулахгүй байх,<br>5. 30 Дж энергитэйгээр дээрээс унасан зүйл толгойд хүрэхгүй байх,<br>6. LD-гэрлийн нөлөөллөөс толгойг найдвартай хамгаалах чадвартай<br>7. 300 гр-аас илүүгүй жинтэй байх, агаар оруулах салхивчтай, усны хаялагатай<br>8. Толгойн дээр тогтож байх зориулалтын бэхэлгээний системтэй байх<br>**9.** Polyethelene-PE, polycarbonat-PC материалаар хийсэн байна. |
| **Дуулганы бүтэц** | 1. Толгойд өмсөх бүслэвчтэй<br>2. Толгойн бүслэвч туузны өргөн 15 мм-ээс багагүй байна.<br>3.Толгойд тохируулах цагирагтай<br>4. Толгойн оройноос хөндийрүүлэх татуургатай байна.<br>5. Толгойн хэмжээнд бүрэн тохируулах тохируулагчтай байна. Өнгө үзэмж сайтай байх ба толгойнд тогтоогч сүлжмэл тууз нь 4 цэгт бэхлэгдсэн байна.<br>6. Хамгаалалтын дуулга нь унахгүйгээр толгойн дээр тогтож байх зориулалтын бэхэлгээний системтэй байна.<br>7. Дуулганы жин 300гр-с ихгүй байна.<br>8. Толгойн хөлс шингээгч жийргэвчтэй байна. |
| **Жишиг зураг.**<br><br>**Цагаан-ИТА** |   |

| | |
|---|---|
| **Шар-Ажилтан** |     |

**Өнгө, захиалах тоо ширхэг:**

| **Нийлүүлэгдэх тоо ширхэг** | |
|---|---|
| Дуулга /каск/ ил уурхайд ашиглагдах | **110** |
| Өнгө /цагаан/ инженер техникийн ажилтан | 30 |
| Өнгө /шар/ ажилтан | 80 |

**12.Дуулга /Далд уурхайд ашиглах/**

| Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлтийн утга |
|---|---|
| **Техникийн үзүүлэлт** | 1. Дуулганы ММ-механик үйлчлэл 400-1000 VAC<br>2. цахилгаан хүчдэл $-50^{0}$С-ээ +150 температур,<br>3. Дуулганы их бие нь толгойд ирэх 50 Дж цохилтын энерги дамжуулахгүй<br>4. 5 кН-с их хүчийг толгой руу дамжуулахгүй<br>5. 30 Дж энергитэйгээр дээрээс унасан зүйл толгойд хүрэхгүй байх бүтэцтэй байна.<br>Материал: LD-гэрлийн нөлөөллөөс толгойг найдвартай хамгаалах чадвартай polyethelene-PE, polycarbonat-PC материалаар хийсэн байна. |
| **Дуулганы бүтэц** | 1. Толгойд өмсөх бүслэвчтэй<br>2. Толгойн бүслэвч туузны өргөн 15 мм-ээс багагүй байна.<br>3. Толгойд тохируулах цагирагтай<br>4. Толгойн оройноос хөндийрүүлэх татуургатай байна.<br>5. Толгойн хэмжээнд бүрэн тохируулах тохируулагчтай байна. Өнгө үзэмж сайтай байх ба толгойнд тогтоогч сүлжмэл тууз нь 4 цэгт бэхлэгдсэн байна.<br>6. Хамгаалалтын дуулга нь унахгүйгээр толгойн дээр тогтож байх зориулалтын бэхэлгээний системтэй байна.<br>7. Дуулганы жин 300гр-с ихгүй, усны хаялагатай байна.<br>8. Толгойн хөлс шингээгч жийргэвчтэй байна. |

| | |
|---|---|
| **Жишиг зураг.**<br><br>**Цагаан-ИТА** |     |
| **Шар-Ажилтан** |   |

| **Нийлүүлэгдэх тоо ширхэг** | |
|---|---|
| Дуулга /каск/ далд уурхайд ашиглагдах | **100** |
| Өнгө /цагаан/ инженер техникийн ажилтан | 30 |
| Өнгө /шар/ ажилтан | 70 |

**13. Техникийн тодорхойлолт /Засварчны өвдгөвч/**

1. Ерөнхий шаардлага

1.1. Гадна талдаа үхрийн гүйцэт боловсруулсан арьсаар хийсэн материалтай байна.

1.2. Дотор талдаа эсгий зөөлөвчтэй өмсөж тайлахад хялбар байна.

1.3. Зөөлөн зангуу болон 5 см зөөлөн резин татлагатай байна.

1.4. Хар бараан өнгөтэй байна.

Жишиг зураг:






| **Нийлүүлэгдэх тоо ширхэг** | |
|---|---|
| Засварчны өвдгөвч | **100с** |

## 14. Түлшний сав цэвэрлэгээний баг /хорт хий, угаарын дамартай хоолойтой/

<u>Техникийн үзүүлэлтүүд:</u>

| | |
|---|---|
| Марк загвар | • ГП-5 (гражданскийн противогаз) эсхүл түүнтэй дүйцэхүйц /Нүүрний битүү маск/ |
| Тохиромжтой байдал | • Хөнгөн авсаархан,<br>• Угсрахад хялбар холбогчтой<br>• Битүүмжлэл шалгахад хялбар |
| Стандарт | • EN 140:1998 |
| Хамгаалалт | • Амьсгалын зам, нүүр, нүдийг хорт болон цацраг идэвхт бодисын нөлөөллөөс хамгаалах, эмгэг төрүүлэгч микроб, хорт бодисоос хамгаалах зориулалттай |
| Холболтын хэлбэр | • Хошуувч, резьба бүхий уян хоолой |
| Материал | • Силикон |
| Хамгаалалтын хэлбэр | • Бүрэн хамгаалалтын иж бүрдэл<br>• Хамгаалалтын үйл ажиллагааны зарчим нь амьсгалсан агаарыг хортой хольцоос урьдчилан цэвэрлэх (шүүх) |
| Хэрэглэгдэх салбар: | • Химичлэл<br>• Хүнд хөнгөх үйлдвэр<br>• Уул уурхай<br>• Шатахуун<br>• Засвар<br>• Ариутгал |
| Тусгай шаардлага | • Хийн маскны хайрцаг нь цилиндр хэлбэртэй байна.<br>• Иж бүрдэлд хийн маск хийх уут, манангаас хамгаалах хальстай байна.<br>• Манангийн эсрэг хальс нь нүдний шилийг манангаас хамгаалах зориулалттай байна.<br>• Нэмэлтээр дамартай 18-20 метр хоолойтой байна |
| Жишиг зураг |   <br> |

Нийлүүлэгдэх тоо ширхэг

| № | Барааны нэр | Хэмжих нэгж | Размер /ширхэг | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Түлшний сав цэвэрлэгээний баг /хорт хий, угаарын дамартай хоолойтой/ | Ширхэг | У2 | У3 | 3 |
| | | | 2 ш | 1 ш | |

**БАГЦ №2. НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ИЖ БҮРДЭЛ**

**Ерөнхий шаардлага**

Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн багц нь дотроо 5 нэгж төрлийн хамгаалах хэрэгсэлтэй багц юм.

**Үүнд:**

1. Бээлий болон түлхүүрний хавчаар
2. Хүчдэл мэдрэгч
3. Саравчтай хамгаалалтын малгай
4. Бээлий
5. Хяналтын камер: Хоёр талд бичдэг камер

**1. Бээлий болон түлхүүрний хавчаар**

**Ерөнхий шаардлага:**

- Бээлийний хавчаар нь нэг талдаа бээлий хавчах хавчаартай нөгөө талдаа түлхүүр оосорлох өмдний түдүүлээс оосорлох төмөр оосорлогчтой байна.
- Бээлийний хавчаарын нийт урт нь 10-13 см байна. өргөн нь 2.5 см байна
- Өнгө: шар эсхүл улбар шар

ЖИШИГ ЗУРАГ:






**2. ХҮЧДЭЛ МЭДРЭГЧ**

**Ерөнхий шаардлага:**

- Хүчдэл мэдрэгч нь 220В, 10кВ хүртэлх хүчдлүүдийг зайнаас мэдрэх чадвартай байна.
- Товчин батерейгаар ажилладаг байна.
- Толгой хамгаалах дуулга /Каска/  болон бусад газар тогтоох боломжтой байна.

ЖИШИГ ЗУРАГ:



## 3. САРАВЧТАЙ ХАМГААЛАЛТЫН МАЛГАЙ

**Техникийн үзүүлэлт:**

1.1 толгойд ирэх 50 Дж цохилтын энерги толгойд хүрэхгүй байх,
1.2 5 кН-с их хүчийг толгой руу дамжуулахгүй байх,
1.3 30 Дж энергитэйгээр дээрээс унасан зүйл толгойд хүрэхгүй байх,
1.4 300 гр-аас илүүгүй жинтэй байх, агаар оруулах салхивчтай, усны хаялагатай
1.5 Толгойн дээр тогтож байх зориулалтын бэхэлгээний системтэй байх
1.6 polyethelene-PE, polycarbonat-PC материалаар хийсэн байна.

**Малгайн бүтэц:**

2.1 толгой хамгаалах дуулгын их бие:
2.2 толгойн оройноос хөндийрүүлэх хэсэг
2.3 бүслэвчийг толгойд тохируулах цагираг
2.4 тохируулагч нь ихсгэж, багасгадаг тохируулгатай
2.5 толгойн хөлс шингээгч жийргэвчтэй
2.6 саравчны урт 50 мм-ээс ихгүй байна.

**3. Хэрэглэх ба шалгах арга:**

Толгой хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зөв угсарсан эсэх, техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөлд тохирч буй эсэхийг нарийн шалгаж, тогтооно.

Өнгө: Шар ногоон

ЖИШИГ ЗУРАГ:











Амьсгалах боломжтой тор

Доргион шингээгч хөөс

Хөлс шингээгч

Амьсгалах боломжтой тор





## 4. БЭЭЛИЙ

1. Ерөнхий шаардлага:
   1. бээлий нь MNS5622:2011 Монгол улсын стандарт, MNS ISO 4418:2011 болон Олон улсын EN388, EN420 EN347 –S1, S2, S3, EN11611 стандартыг бүрэн хангасан байна.
2. Загвар бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:
   1. Хүний биед харшил үүсгэхгүй материалаар хийгдсэн хөлстэй урвалд орох шинж чанаргүй, бактери үржүүлдэггүй байх.
   2. Гарыг механик болон химийн бодисны, хүйтний үйлчлэлээс хамгаалах зориулалттай байх бөгөөд стандартын шаардлагад нийцсэн эсэхийг хянан тодорхойлохдоо зөвхөн загвар бүтээгдэхүүнийг бодитоор хүлээн авч хэмжилт, туршилт хийж тодорхойлно.
   3. Гарын сайн зууралттай цохилтод тэсвэртэй бээлий.
   4. Удаан хугацааны туршид элэгдэл бага нитрил бүрхүүлтэй
   5. Эрхий хуруу болон бүх хэсэгт нэмэлт хамгаалалттай.
   6. Бугуйн оосор
3. Техникийн үзүүлэлт:
   1. Сунадаг сайн зууралддаг материалтай байх.
   2. Гарт эвтэйхэн, бат бөх, сайн чанарын, 5 хурууны бээлий байна. 60 гр-с багагүй жинтэй
   3. Утсаар шигүү нэхсэн, зузаан, алга болон хуруунд нь хамгаалалттай байна.

ЖИШИГ ЗУРАГ:




## 5. ХЯНАЛТЫН КАМЕР /ХОЁР ТАЛДАА БИЧДЭГ /

Техникийн үзүүлэлт:

1. Зориулалт: Тухайн камераар FULL HD хэлбэрээр хянах объектын хоёр талын /Front & Back/ хөдөлгөөн, үйлдлийг бүрэн хянах, баримтжуулах.
2. Дуран :1440P
3. Интернэтэд холбогдож ажиллах: WiFi
4. Ашиглах программ хангамж: Гар утасны тусгайлсан аппликэйшнтэй.
5. Аудио: Микрофон, спикетэй. Орчны дуу бичнэ.
6. Нэг талын камер 170 градус өргөн өнцөгөөр хяналтыг хийнэ.

7. Дэлгэц: 2.7 инч LCD
8. Сууриуулах хэлбэр: Машины цонх, шилэнд наах тусгай наалт дагалдана.
9. Карт: 32GB-ын мемори карт дагалдана.
10. Холболт: USB оролт
11. Шөнийн цагийн бичлэг: Хийнэ. Шөнийн горимтой байх.
12. Хөдөлгөөн илэрсэн үед өөрөө автоматаар ажиллаж бичлэг хийнэ.
13. Машинд суурлуулах тогтоогчтой байна.

ЖИШИГ ЗУРАГ:




**Барааны чанарыг шалгах:**

Хамгаалах хэрэгслийг Монгол улсын MNS 4931:2000 стандартын шаардлага хангасан эсэх, ажилтныг аюул, эрсдэлээс хамгаалах чанарын шаардлага хангасан эсэхийг магадлан баталгаажуулахын тулд санал болгож буй загвар бүтээгдэхүүнийг авч шалгаж магадлана.

**Барааг шалгаж хүлээн авах:**

Шалгалт,туршилт: Тендерт оролцогч нь тендерийн үнэлгээний шалгалт, туршилтын зориулалтаар өөрийн санал болгож байгаа бараа тус бүрээс 1 ш /эсвэл 1 хос/-ээс доошгүй загварыг заагдсан стандартын шаардлагыг хангасан тухай эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох чанарын сертификатыг хавсарган ирүүлнэ. Загварыг бохирдох, муудах болон ус чийгээс хамгаалах тус бүрээр гялгар уутанд нэр шошго, тэмдэглэл хийж савласан байна.

Барааг “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ-ийн Төв агуулахад нийлүүлэгчийн төлөөлөгч байлцаж, хамтарсан шалгалт туршилт хийж баталгаажуулна.

Холбогдох стандартын шаардлага болон техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй буюу ажилтанд олгож ашиглуулах боломжгүй хамгаалах хэрэгслийг хүлээн авахгүй бөгөөд хүлээн авсан бараанаас эвдрэл гэмтэлтэй бараа бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд буцааж солиулах болно.